МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,111.284... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.10.20. Пүрэв. №187 (4557) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

**ОНЦЛОХ ХУУДАС**

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРТ ТУРШЛАГА ДУТАХ САЙД

V нүүрт

**ДЭЛХИЙ**

ХЭТ ДАВРАГЧИД МОСУЛЫГ АЛДВАЛ, ЕВРОП РУУ ХАЛДАНА

VI нүүрт

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**




Дугаарын 60 мөр

## Улс төржиж болдоггүй салбар гэж байдаг юм шүү

Ж.ОТГОНМЯГМАР

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдрал, насан туршид нь нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр тул иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг байдаг. Гэтэл сүүлийн үед төр энэхүү үүргээ умартаж эхлээд байна. Өөрөөр хэбэл, хүнийг хүн болгох хамгийн том хөдөлгөгч суурь боловсролын эрүүл механизм үгүйлэгдэх боллоо. Өмнөх Засгийн үед буюу АН төр барьж байхдаа ерөнхий боловсролын сургуулиудад “Цөм” хөтөлбөр гээчийг хэрэгжүүлж эхэлсэн. Тодруулбал, сургах гэдэг ухагдахууныг суралцах гэдгээр солих зорилго бүхий “Цөм” хөтөлбөрийг энэ хичээлийн жилээс хэрэгжүүлж эхлээд байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

СОНГУУЛЬ-2016

# ТҮҮХЭНД БАЙГААГҮЙ МУУ ИРЦТЭЙ СОНГУУЛЬ БОЛЛОО




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дэлгэрэнгүйг II-III нүүрнээс




АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

## С.МӨНХНАСАН: БИД ҮНДЭСНИЙ КОМПАНИА ХАМГААЛЖ, ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛЭЭ ХӨГЖҮҮЛНЭ

Н.БАТЗАЯА

*Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга С.Мөнхнасантай ярилцлаа.*

**-Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын бүтээн байгуулалтын ажлыг хүн бүр сонирхож, ашилалтад орохыг нь хүлээж байна. Барилгын ажил хэдэн хувьтай явагдаж байна вэ?**

-Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудал нь манай улсын хэмжээнд хэрэгжиж байгаа томоохон төслийн нэг. Монгол Улс Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжсэн “Буянт-Ухаа” нисэх буудлыг сайжруулах төслийн дараа шинэ олон улсын нисэх онгоцны буудалтай болох бодлого барьж ажилласан. Энэхүү бодлогын хүрээнд анх 2006 оны гуравдугаар сард Япон улсын Засгийн газарт Улаанбаатар хотын ойролцоо Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт Хөшигийн хөндийд Олон Улсын шинэ нисэх онгоцны буудал барих тухай төслийг санал болгосон. Харин Монгол Улсын Засгийн газар уг төслийг Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх талаарх албан ёсны хүсэлтийг 2006 оны зургадугаар сарын 28-нд Япон улсын Засгийн газарт тавьсан юм. Энэ мэтчилэн олон удаагийн санал хүсэлт тавьсны үр дүнд “Улаанбаатар хотын Клон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл”-ийг хэрэгжүүлэхээр болж, Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох “MON-P8” хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг 2008 оны тавдугаар сарын 1-нд байгуулан УИХ-аар соёрхон баталсан түүхтэй.

Үргэлжлэл нь IV нүүрт




| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2315.00 | 2333.00 | ФУНТ | 2798.00 | 2902.00 |
| ЕВРО | 2519.00 | 2592.00 | РУБЛЬ | 35.40 | 38.50 |
| ИЕН | 22.06 | 22.68 | ЮАНЬ | 342.50 | 346.40 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2314.00 | 2331.00 | ФУНТ | 2799.00 | 2889.00 |
| ЕВРО | 2521.00 | 2603.00 | РУБЛЬ | 35.57 | 38.90 |
| ИЕН | 22.01 | 22.79 | ЮАНЬ | 342.00 | 346.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## “Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх нь

Монгол Улсын хүн амын өсөлт, төрөлтийг дэмжих бодлогын хүрээнд Эхэд тэтгэмж, хөнгөлөлт олгох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг даалгав. Төслийн үзэл баримтлалд тусгаснаар 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхэд улирал бүр цалин олгох “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлэх, Нийгмийн даатгалын шимтгэлийг нь 100 хувь төрөөс хариуцах, мөн гурав буюу түүнээс олон хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-т хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр улирал бүр дэмжлэг үзүүлэхээр тусгажээ. Манай улсын нийт өрхийн 72.8 хувь нь 1-2 хүүхэдтэй юм байна. Иймд нэг өрхөд ногдох хүүхдийн тоог нэмэгдүүлэх, олон хүүхэдтэй өрхийг дэмжих нь зүйтэй гэж Засгийн газар үзлээ. Ингэснээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх боломж бүрдэж байгаа бөгөөд цаашид эхчүүдийн цалинг сар бүр олгох чиглэл барихыг даалгалаа.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

СОНГУУЛЬ-2016

# ТҮҮХЭНД БАЙГААГҮЙ МУУ ИРЦТЭЙ

–Сонгуулийн эцсийн дүн долоо хоногийн дараа гарна–

Ж.ОТГОН

*Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгууль боллоо. Санал хураалт 07:00-22:00 цагийн хооронд явагдсан юм. Энэ удаагийн сонгуулиар 21 аймгийн 1613 баг, нийслэлийн есөн дүүргийн 152 хорооноос нийт 7282 төлөөлөгч сонгогдох учиртай. Эдгээр 7282 мандатын төлөө өрсөлдөхөөр 15212 нэр дэвшигч бүртгүүлснээс улс төрийн нам, эвслээс 14489, харин бие даан 723 нэр дэвшигч бүртгүүлжээ. Үүнээс 4530 нь эмэгтэй нэр дэвшигч байв. Энэ удаад сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд МАН, АН, ИЗНН, Монголын Ногоон нам, Бүгд найрамдах нам, МАХН, Ардчилсан нам-Монгол Ардын Хувьсгалт намын “ТӨВ НУТАГ” эвсэл, Эх Орон Нам, Монгол Үндэсний Ардчилсан нам, Хөдөлмөрийн Үндэсний нам оролцлоо. Мөн сонгууль зохион байгуулахаар 1765 тойргийн, 2082 хэсгийн хороо ажиллав. Орон нутгийн сонгуульд зориулж нийт 1765 төрлийн хоёр сая гаруй саналын хуудас хэвлүүлж хэсгүүдэд хүргүүлсэн бөгөөд сонгуулийг нийтдээ 13.9 тэрбум төгрөгөөр зохион байгуулсан байна.*



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН







### 12:00 цагийн байдлаар сонгогчдын ирц 16.8 хувьтай байв

Энэ удаагийн сонгууль нэлээд ирц муутай эхэлсэн юм. Тухайлбал, 12:00 цагийн байдлаар нийслэлийн 110404 сонгогч саналаа өгч, ирц 12.84 хувьтай байсан. Орхон, Баян-Өлгий, Увс зэрэг аймгуудад 10 гаруйхан хувьтай байсан бол улсын хэмжээнд сонгогчдын ирц нийт 16.8 хувьтай байсан юм. Энэ талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн “Улсын хэмжээнд сонгогчийн ирц тааруу байна. Зарим газар цастай, даваа гүвээ хаагдсан гэх зэрэг санал өгөхөд бэрхшээлтэй байгаа тухай мэдээ ирж байна. Бидний зүгээс иргэдийн сонгох эрхийг хангахын тулд Онцгой байдлынхантай хамтран ажиллаж байгаа. Мөн сонгууль өгөх өдрийг төрөөс бүх нийтийн амралтын өдөр байна гэж заасан байгаа. Гэтэл зарим байгууллагуудаас ажилчдаа амраахгүй байна гэсэн гомдол ирсэн. Тиймээс бид тухайн байгууллага, салбарын удирдлагатай холбогдож, зохицуулах арга хэмжээ авч байна” гэдгийг дуулгасан юм. Харин сум, дүүргийн сонгуулийн ирц 17:00 цагийн байдлаар аймгийн дундаж 49.1, улсын хэмжээнд 40.9 хувьтай байлаа. Энэ үеэр сонгуулийн ирц нь бүрдсэн 10 аймаг байв. Тухайлбал, Архангай 55.3, Баян-Өлгий 56.9, Баянхонгор 54.5, Говь-Алтай 56.2, Завхан 62.3, Сүхбаатар 61.4, Төв 50.4, Увс 56.6, Ховд аймаг 57.1 хувийн ирцтэй байсан юм. Нийслэлийн сонгогчид сонгуульдаа тун идэвхгүй оролцлоо. 12:00 цагийн байдлаар ирц 12.84 хувьтай байсан бол 17:00 цагийн байдлаар 30.9 болж нэмэгдсэн юм. Дүүргүүдээс Багахангай дүүрэг хамгийн өндөр ирцтэй буюу 52.7 хувьтай байлаа. Харин хамгийн бага нь Сонгинохайрхан дүүрэг 27.9 хувийн ирцтэй байсан юм.

### Дүүргүүдийн хувьд ирц хангалтгүй байлаа

Сонгогчдын идэвх муу, ирц сул байгаа учир хэсгийн хороодын ажилчид иргэдийг саналаа өгөхийг уриалах, дуудах ажлыг хийж эхлүүлсэн. Уг нь орон нутгийн хувьд ирц харьцангуй өндөр, хангалттай байгаа ч нийслэлд ирц бага байлаа. Улмаар санал хураалтын үйл ажиллагаа журмын дагуу 22:00 цагт өндөрлөв. Ингээд дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн ирцийн нэгдсэн дүнг Нийслэлийн сонгуулийн хороо 00.30 цагт мэдээлэл өгөх байсан. Гэвч зарим хэсгийн хорооноос ирцийн мэдээллийг эцсийн байдлаар өгөөгүй байгаа тул дүнг хараахан нэгтгэж амжаагүй байна гэх шалтгаанаар дугаар шилжих мөчид буюу 00:50 цагт мэдээлэл өгөөгүй л байлаа. Ирцийн тухайд нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэгт ирц хангалтгүй байгааг эх сурвалжууд мэдээлж байна. Тухайлбал Чингэлтэй дүүрэг 19 хороотойгоос 4-5 хорооных нь бүрдсэн, бусад хорооны ирц бүрдээгүй гэв. Тэгэхээр ирц бүрдээгүй хэсэгт дахин санал хураалт явуулна. Дахин санал хураалт энэ сарын 29-нд болох юм. Харин сонгуулийн ирцийн талаар Сонгуулийн Ерөнхий хорооноос 22:30 цагт мэдээлэл хийх тов гарсан байсан. Гэсэн хэдий ч ирцийн мэдээллийг орон нутгаас нэгтгэж байгаа учир мэдээлэл хийх боломжгүй сонгуулийн урьдчилсан дүнг өнөөдөр танилцуулахаар болсон гэдгийг дуулгасан.

### Завханд АН, Баян–Өлгийд МАН үнэмлэхүй ялалт байгуулжээ

Нийслэл, аймгийн сонгуулийн хороод дүнг тав хоногт багтан хэлэлцэж, орон нутгийн хурлын төлөөлөгчөөр сонгогдсон нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт болон тэдний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх учиртай. Өөрөөр хэлбэл, сонгуулийн дүн мэдээ аравдугаар сарын 26-ны лхагва гарагт эцсийн байдлаар тодорхой болох юм. Улмаар шинээр сонгогдсон төлөөлөгчдөө аймаг, нийслэл, сум, дүүргийн хуралд өргөн мэдүүлж, энэ тухайгаа СЕХ болон нийтэд долоо хоногийн дотор мэдээлэх ёстой юм. Эх сурвалжуудын мэдээлж буйгаар урьдчилсан байдлаар Хөвсгөлийн 23 сумын зургаад нь АН, 17-д МАН ялсан бол Завханы 24 сумаас 19-д АН, хоёр суманд МАН, гурван сумын дүн гараагүй, Баянхонгор аймгийн 20 сумын тавд нь АН, 14-д нь МАН ялсан бол нэг сум нь асуудалтай байгаа гэнэ. Түүнчлэн Увсын Зүүнговьд АН 19, МАН хоёр суудал авсан бол бусад сумдад нь МАН ялсан байна. Ховдын Буянт зэрэг суманд АН ялсан бол Дундговийн 15 сумаас тавд нь АН, 10 суманд МАН, Сэлэнгийн 17 сумаас долоод нь АН, 10 суманд МАН, Говьсүмбэрийн гурван сумаас нэгд нь АН, хоёрт нь МАН, Дорноговийн 14 сумаас гуравт АН, 10 суманд МАН ялсан гэсэн мэдээ ирлээ. Харин Архангай цэцэрлэгт, Төв аймгийн Зуунмод зэрэг 16 суманд МАН ялсан бол 27 сумаас Архуст, Эрдэнэсант, Батсүмбэр, Өндөрширээт, Баянцагаан, Заамар, Баяндэлгэр зэрэг 10 суманд АН ялж, Сэргэлэн суманд тэнцсэн байна. Дундговь аймгийн Цагаандэлгэр, Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай суманд АН ялж, үлдсэн сумдад МАН ялалт байгуулж чаджээ. Баян-Өлгий аймгийн хувьд бүх суманд нь МАН ялсан бол Дорноговийн 14 сумаас гуравт нь АН, 10 суманд МАН ялсан байна. Өвөрхангай аймгийн Хархорин, Баян-Өндөр, Баруун баянулаан, Тарагт, Уянга, Төгрөг сумдад АН үнэмлэхгүй ялалт байгуулсан гэсэн мэдээлэл байгаа юм. Баянхонгор 20 сумаас долоон суманд АН, бусад нь сумдад МАН, Хэнтий аймгийн 22 сумын 17 сумаас мэдээ ирсэн бөгөөд 17 сумын зургаад нь АН, есөн суманд МАН, Өмнөговийн 15 сумаас гурван суманд АН, 12 суманд МАН, Булганы 16 сумын гуравт нь АН, 13 суманд МАН ялалт байгуулжээ. Нийслэлийн хувьд Сонгинохайрхан, Багануурт дүүрэгт МАН ялсан байна. Харин Хан-Уул 16 тойргоос тав нь ирц хүрээгүй, 11 хорооноос тавд нь АН, зургаад нь МАН ялсан, Налайх дүүрэгт АН дөрөв, МАН 21 суудал авсан байна. Түүнчлэн Хан-уул дүүргийн хэмжээнд АН найм, МАН ес, бие даагч хоёр суудал авсан гэх мэдээлэл байна.

Дашрамд дуулгахад, Сүхбаатар аймаг өнгөрсөн сонгуулиар ИТХ-н 33-н суудлаас АН 16, МАН 16, болон тэнцэж



## ҮЗЭЛ БОДОЛ

# СОНГУУЛЬ БОЛЛОО

Дарьганга сумын гуравдугаар тойрогт дахин сонгууль зарлагдсан билээ. Өчигдөр болсон орон нутгийн сонгуулийг улс даяараа чих тавин хүлээж байлаа. Учир нь Ардчиллын түүхэнд 2004, 2008, 2012 оны сонгуулиудад дараалсан ялалтуудыг авч ажиллахдаа Монгол Улсын шилдэг аймгаар дөрвөн удаа шалгарч байсан түүхтэй юм. Орон нутгийг яаж бие даан хөгжүүлж болдгийг аль ч намын засгийн газартай хамтарч ажиллаж чаддагаа Монголын ард түмэнд харуулсан баг бүрэлдэхүүнд дахин итгэл өгөх эсэх нь сонирхол татаж байлаа. Тэгвэл өчигдрийн сонгуульд дахин ялалт байгуулж, дөрвөн сонгууль дараалсан ялалтын эзэд боллоо. Энэ удаагийн сонгуулийг Аймгийн АН-н дарга Монгол Улсын шилдэг менежер Сүхбаатар аймгийн 16 дахь засаг дарга Ж.Батсуурь гардан удирдаж, АН-аас ИТХ-н Дарга Паламын Мөнхжаргал өрсөлдөж, үнэмлэхүй хувиар ялж, МАН-аас хууль зөрчин Засаг даргын үүргийг гүйцэтгэж байгаа гэх Занын Энхтөр өвдөг шороодлоо. Сүхбаатарчуудын анхаарлыг удтал татсан сонгууль эцэс болж Ардчилсан нам бодлогоо хэрэгжүүлэх бүтээн байгуулалтаа үргэлжлүүлж, ард түмнийхээ сайн сайхан амьдралын төлөө ажиллах боломж бүрджээ. Сүхбаатар аймгийн хувьд 13 сумын долоод нь АН, зургаан суманд МАН ялалт байгуулсан гэсэн урьдчилсан мэдээ ирээд байна.

### Төрийн гурван өндөрлөг иргэний үүргээ биелүүллээ

Төрийн гурван өндөрлөгийн хувьд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Сүхбаатар дүүргийн гуравдугаар хороо, Монгол-Оросын хамтарсан гуравдугаар сургуульд байрлах сонгуулийн хэсгийн хороонд саналаа өгсөн юм. Харин УИХ-ын дарга М.Энхболд өчигдөр Чингэлтэй дүүргийн сонгуулийн нэг дүгээр тойрог, 2036 дугаар хэсгийн санал авах байранд буюу нийслэлийн 23 дугаар дунд сургууль дээр саналаа өглөө. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 12:30 цагт Баянзүрх дүүргийн ИТХ-ын сонгуулийн 1834 дүгээр хэсгийн хороонд очиж саналаа өгөв.

> ...Улсын хэмжээнд сонгуульд оролцох насны нийт иргэддээ хандаж хэлэхэд, өмнөх орон нутгийн сонгуулийн ирцийг өнөөдрийн сонгуулийн ирцтэй харьцуулвал ирц хүрэхгүй байж болохуйц байдал ажиглагдаж байна. Иймээс иргэд, олон түмэн сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалж байна...

### Ц.Элбэгдорж: Хамгийн их зүйл хийх хүмүүсээ сонгох сонгууль болж байна

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж гэргий Х.Болормаагийн хамт Монгол-Оросын хамтарсан III сургууль дээр байрлаж буй хэсгийн хороонд очиж саналаа өгөв. Саналаа өгснийхөө дараа тэрбээр хэлэхдээ "Та бүхний энэ өдрийн түмэн амгаланг айлтгая. Энэ удаагийн сонгууль иргэд, хүмүүст хамгийн ойрхон ажиллах төлөөлөгчдөө сонгож байгаа сонгууль юм. Иргэдэд хамгийн ойрхон ажиллаж, хамгийн их зүйл хийх хүмүүсээ сонгох сонгууль болж байна. Нийт иргэддээ сонгуульдаа идэвхтэй оролцохыг хүсч байна. Бүгдэд нь амжилт хүсье. Баярлалаа" гэлээ.

### Ж.Эрдэнэбат: Монголын иргэд мэргэн сонголт хийж, МАН–д итгэл үзүүлнэ

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Баянзүрх дүүргийн 25 дугаар хорооны 1834 дүгээр хэсгийн хороонд орон нутгийн ИТХ-ын сонгуульд санал өглөө. Тэрбээр, "Иргэний үүргээ биелүүлж, ИТХ-ын сонгуульд саналаа өглөө. Засгийн газраас иргэдийн амьдралыг дээшлүүлэх, хүн бүрийг ажилтай, орлоготой байлгахын төлөө ажиллаж байна. Монголын эдийн засгийн нөхцөл байдал маш хүнд байгаа энэ үед бид 1000 цэцэрлэг барих мөнгийг зээлийн хүүнд төлж байгаа. Энэ нөхцөл байдлыг давж гарахын тулд бид орон нутгийн сонгуульд амжилт үзүүлэх шаардлагатай. Тиймээс Монголын иргэд мэргэн сонголт хийж, МАН-д итгэл үзүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Иргэдийг бас улс орныхоо цаашдын ирээдүй, хөгжлийн төлөө сонгуульд идэвхтэй оролцох хэрэгтэй" гэлээ.

### М.Энхболд: Сонгуулийн ирц хүрэхгүй байж болохуйц байдалтай байна

УИХ-ын дарга М.Энхболд өчигдөр Нийслэлийн 23 дугаар дунд сургуульд байрлах Чингэлтэй дүүргийн сонгуулийн нэг дүгээр тойрог, 2036 дугаар хэсгийн санал авах байранд очиж саналаа өглөө. Тэрбээр саналаа өгсний дараа "Өнөөдөр аравдугаар сарын 19-ний өдөр. УИХ-ын гаргасан шийдвэрийн дагуу орон нутгийн сонгууль явагдах ёстой өдөр. Би Чингэлтэй дүүргийн нэгдүгээр хороонд амьдардаг. Тиймээс хорооныхоо нутаг дэвсгэр дэх санал авах байранд ирж саналаа өглөө. Улсын хэмжээнд сонгуульд оролцох насны нийт иргэддээ хандаж хэлэхэд, өмнөх орон нутгийн сонгуулийн ирцийг өнөөдрийн сонгуулийн ирцтэй харьцуулвал ирц хүрэхгүй байж болохуйц байдал ажиглагдаж байна. Иймээс иргэд, олон түмэн сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалж байна. Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага бол дөрвөн жилийн хугацаанд тухайн орон нутгийн хөгжлийн болоод хүндрэл бэрхшээлтэй асуудлыг дээд шатны байгууллагадаа хүргэдэг. Дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг орон нутагт хэрэгжилтийг нь хангадаг чухал байгууллага юм. Өөрөө удирдах ёсны энэхүү байгууллагаа байгуулахад иргэд бүрэн эрхийнхээ дагуу идэвхтэй оролцох нь зүйтэй юм" гэв.







ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын 60 мөр

## Улс төржиж болдоггүй салбар гэж байдаг юм шүү

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Уг нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө туршиж үзээд, олон давуу талууд бий болж байна хэмээн үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр болсон. Тухайн үед уг хөтөлбөрийг хэрэгжүүлж туршихад багш нарын идэвх эрс сайжирч, хоорондоо санал бодлоо солилцож, хамтран хөтөлбөр гаргадаг болсон. Өөрөөр хэлбэл, санаачилгыг сургуульд тэр дундаа багш нарын гарт шилжүүллээ. Харин сурагчдын хувьд нэгдүгээрт, амьдрах ухаантай хүн бэлтгэх, хоёрдугаарт, мэдлэг чадваруудыг олгохын зэрэгцээ боддог, бодоод шийддэг, шийдсэн шийдвэрээ илэрхийлдэг цогц чадварыг олгож болох нь. Өөрөөр хэлбэл, тухайн хүүхэд шинийг сэтгэгч, шинийг эрэлхийлэгч байж, цоо шинэ нийгмийн бүтээж чадна. Гуравдугаарт, бие дааж идэвхтэй суралцах буюу хүүхэд бүхэнд "би чадна" гэсэн итгэтгэлийг өгөх хөтөлбөр болж чаджээ гэж дүгнэж байсан.

Гэтэл Засаг солигдсон учир өнөөх сайн, сайхан хөтөлбөр нь хэнд ч хэрэггүй хог, новш болоод хувирчихлаа. Угаасаа аль ч засагт салбарын сайдууд өмнөх сайдынхаа ажлыг үгүйсгэж, үгүй юм аа гэхэд ямар нэг өө олж муулдаг. Илүү зүйл хийж харагдахын тулд цоо шинийг эхлүүлдэг. Чадахгүй бол өмнөх зүйлийн нэрийг нь өөрчилж хийдэг жишиг тогтчихоод байгаа. Тэгвэл энэхүү гажиг жишиг боловсролын салбарыг тойрсонгүй. Мэдээж шинэ зүйл учир мэдэхгүй, чадахгүй зүйл олон гарах нь ойлгомжтой. Тиймээс ч дөнгөж хэрэгжиж эхлээд байгаа хөтөлбөрийнхөө учрыг олох гэж багш, сурагчид болоод эцэг, эхчүүд будилах зүйл цөөнгүй гарч байгаа. Гэтэл үүнтэй зэрэгцээд салбарын сайд нь "Цөм" хөтөлбөрийг цөм муулах боллоо. Саяхан тэрбээр ""Цөм" хөтөлбөрийг гаргасан хүмүүс нь ч өөрсдөө юу хийснээ мэдэхгүй байна" гэсэн гарчиг бүхий ярилцлага нийтлүүлсэн. Гэтэл үүнийг харсан эцэг, эхчүүд "дэлбэртэл" ууралцгааж байна. Арга ч үгүй биз. Сурах бичгийн агуулгыг дур зоргоороо өөрчлөх асуудал сүүлийн жилүүдэд маш их гарч байгаа. Үүнтэй зэрэгцээд, нам, Засаг солигдохтой зэрэгцээд хүүхдийнх нь боловсролоор "тоглоом" хийгээд байгаа болохоор хэн баярлах билээ. Тиймээс улс төржиж болдоггүй салбар гэж байдаг юм гэдгийг ойлгоод, ядаж энэ салбарыг учир утгагүй улс төржилтөөс хэлтрүүлж сурмаар байна.

ЧУХАЛ СЭДЭВ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# С.МӨНХНАСАН: БИД ҮНДЭСНИЙ КОМПАНИА ХАМГААЛЖ, ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛЭЭ ХӨГЖҮҮЛНЭ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Хэлэлцээрийн дагуу Япон Улсын Засгийн газраас 540 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэсэн. Уг төсөл 2008 оны аравдугаар сарын 1-нээс эхлэн Олон улсын хамтын ажиллагааны JICA байгууллагын нэрийн дор амжилттай хэрэгжиж байна. Одоогоос гурван жилийн өмнө нэг ч шонгүй зэлүүд тал газарт шинэ олон улсын нисэх онгоцны буудлын ажлаа эхлүүлж байсан бол одоо төсөл дуусахад 90 гаруй хоног үлджээ. Нийт 825 автомашины зогсоол, 3600 метр зурвас, 37 мянган мкв терминалын талбай, 41 метр өндөр цамхагтай, жилд гурван сая хүн хүлээн авах хүчин чадал бүхий олон улсын стандартад нийцсэн нисэх онгоцны буудлыг хүлээлгэн өгөх хугацаа ойртсон учраас барилгын ажил бараг дуусах дөхсөн гэж ойлгож болно.Одоогийн байдлаар төслийн гүйцэтгэл 96 хувьтай явагдаж байна. Энэхүү төсөл Японы хөнгөлөлттэй зээл болон Монгол Улсын Засгийн газраас санхүүждэг. Тиймээс төслийн хүрээнд хийгдэж буй ажлын гүйцэтгэл харилцан адилгүй байна. Тухайлбал, төслийн үндсэн санхүүжилт болон зээлийн хөрөнгөөр санхүүжсэн ажлууд 97 хувьтай, Монголын талын хариуцсан зарим ажил дууссан. 30-40 хувийн гүйцэтгэлтэй ажлууд бий. Японы талаас Монгол Улсын Засгийн газарт 2017 оны нэгдүгээр сарын 7-нд Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг хүлээлгэн өгөх гэрээтэй. Барилгын ажил дуусмагц нисэх онгоцны буудлыг шууд ашиглалтад оруулахгүй л дээ. Олон улсын иргэний нисэхийн байгууллага, Монгол Улсын дотоодын иргэний нисэхийн байгууллагаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, аюулгүйн гэрчилгээ, сертификат авах ёстой. Бүх үйл ажиллагааны тест, шалгалт хийж, нисэх буудлын төдийгүй агаарын навигацийн тоног төхөөрөмжүүдийг ч хянана. Мөн туршилтын нислэг үйлдэнэ. Энэ мэтчилэн хяналт, шалгалтын ажлыг хийж, аюулгүй байдлыг тодорхойлсны дараа 2017 оны зун ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

**-Агаарын тээврийн салбар дахь бүтээн байгуулалтаас гадна ямар онцгой ажил хийгдэж байна вэ. Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлаас гадна хэрэгжүүлж байгаа ажлаа сонирхуулбал?**

-Сүүлийн жилүүдэд манай иргэний болон агаарын нисэхийн салбарт олон улсын нисэх онгоцны буудлаас гадна томоохон хэмжээний төсөл, хөтөлбөрүүд нэлээдгүй хэрэгжлээ. Бид үндсэн дөрвөн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нэгдүгээрт, хууль эрх зүйн чиглэлд хийсэн ажил гэвэл Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийг батлууллаа. Энэхүү бодлогын бичиг баримтын хэрэгжсэнээр манай улсад олон улсын зорчигч болон ачаа тээврийн бүс нутгийн хэмжээний зангилаа, томоохон хот суурин газруудыг олон улстай холбосон үндэсний агаарын тээврийн нэгдсэн сүлжээ бий болох, агаарын тээвэрлэгч компаниуд олон улсад өрсөлдөх чадвартай болж, Монгол Улсын агаарын тээврийн нэр хүнд өсч, агаарын тээврийн салбарт бүс нутагтаа тэргүүлэх орнуудын хэмжээнд хүрнэ. Мөн гуравдагч ертөнцтэй шууд холбогдон Монгол Улсын гадаад харилцаа, худалдаа өргөжих, иргэний нисэхийн салбарын хөгжилтэй уялдан олон улсын болон орон нутгийн нислэгийн тоо нэмэгдэх юм. Ингэснээр тээврийн тариф буурах, агаарын тээврийн ложистик бүрэн хэмжээгээр хэрэгжих боломж бүрдэхээс гадна аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх зэрэг олон давуу талууд бий болох юм. Уг бодлогын бичиг баримт 2016, 2020 он гэсэн хоёр үе шаттай хэрэгжинэ. Бид өнгөрсөн хугацаанд Иргэний нисэхийн тухай хуулийг шинэчлэн батлах, Иргэний нисэхийн дүрмийг шинэчлэх ажлыг шат дараатайгаар хийж байна. Хоёрдугаарт, 2011 онд агаарын навигацийн чиглэлээр Монгол Улсын агаарын зайд бодит ажиглалтын удирдлагыг нэвтрүүлж, нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг олон улсын жишигт дүйцэхүйц өндөр төвшинд хүргэсэн. Манай улс дээгүүр нисэн өнгөрөх олон улсын нислэгийн тоо жилд 5-10 хувь нэмэгдэж чадсан. Статистик судалгааны дүнг үзэхэд энэ жилийн нислэгийн тоо өнгөрсөн жилтэй харьцуулахад, найман хувиар өссөн ажлын үр дүн гарлаа. Гуравдугаарт, Бид сүүлийн хоёр жил PBN концевцийг Монгол Улсын агаарын зайд нэвтрүүлэх ажлыг хийж байна. Тус концевцийг нэвтрүүлснээр агаарын тээврийн компаниуд шулуун нислэг үйлдэх боломжтой болсон. Шулуун нислэг нь эдийн засаг болон байгаль экологийн талаас маш их ашиг тустай. Тухайлбал, компаниуд шатахуун хэмнэнэ. Шатахуун хэмнэвэл хүлэмжийн хий багасах юм. Энэ мэтчилэн чухал ач холбогдолтой. Агаарын тээврийн салбарт олон ажил хийгдэж байгаа. Ази Европын дээд түвшний уулзалтын үеэр ч бид маш өндөр үүрэг гүйцэтгэж оролцлоо шүү дээ.

...Монгол Улсын агаарын тээвэр маш жижигхэн зах зээлтэй. Манай улсад дотоодын болон гадаадын нийт 7-8 компани нислэг үйлддэг. Тодруулбал, “МИАТ”, “Аэро Монголиа”, “Хүннү Эйр”, “Кориан Эйрлайнс”, Аэрофлот”, “Эйр Чайна”, “Туркиш Эйрлайнс” зэрэг компани бий. Эдгээр компани нийлээд 2012 онд анх удаа нэг сая зорчигч тээвэрлэлээ...

**-Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр хэр анхаарч байна вэ. Шинэ нисэх онгоцны буудалд ямар хүмүүс ажиллах вэ?**

-Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал нийт 900 орчим хүнийг ажлын байраар хангана гэсэн тооцоо бий. Ер нь шинэ нисэх онгоцны буудалд ажиллах боловсон хүчний 80 хувь нь бэлэн гэж ойлгож болно. Учир нь Чингис хаан нисэх онгоцны буудлын ажилчид шинэ нисэх буудал руу шилжиж ажиллана. Тус компани нийт 700 ажилтантай. Тэгэхээр 80 хувь нь бэлэн байна гэж ойлгох хэрэгтэй. Харин 200 орчим ажлын байр шинээр бий болох юм. Эдгээр шинэ ажилчдыг бэлтгэх ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, Японы хамтын ажиллагааны JICA Олон улсын байгууллагатай хамтран техникийн чиглэлээр олон боловсон хүчинг сургалтад хамруулсан. Мөн одоо ажиллаж буй мэргэжилтнүүдийн ур чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

**-Зам, тээврийн салбарт дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх талаар олон ажил хийллээ. Чингис хаан нисэх онгоцны буудал транзит тээврийн заалтай шүү дээ. Энэ заал үр өгөөжөө өгч эхэлсэн үү?**

-Тийм. Транзит тээвэр нь улс орны эдийн засагт маш өндөр ач холбогдолтой. Чингис хаан нисэх онгоцны буудлын транзит заал ч мөн ялгаагүй. Транзит заалтай болсноор ОХУ-ын Сибирийн ройны зорчигчдийг Монголоор дамжуулан Зүүн Өмнөд Ази руу тээвэрлэх боломж нээгдсэн. Гэхдээ транзит заал маань цаг үеийн нөхцөл байдлаас болж бидний төсөөлснөөр хараахан ажиллаагүй байна.Сүүлийн хоёр жил дэлхийн эдийн засаг тэр дундаа ОХУ-ын эдийн засгийн нөхцөл байдал тогтвортой бус байлаа. Манай улс ОХУ хооронд визгүй болсны ашиг гарсангүй. Учир нь эдийн засгийн уналт жуулчдад нөлөөлж, аялагчдын тоо цөөрсөн. Бид цаашид энэ чиглэлд туушгай ажиллана. Транзит тээвэр эдийн засагт өндөр үр нөлөөтэй учраас энэхүү тээврийг хөгжүүлэхэд өндөр ач холбогдол өгөн ажиллаж байна.

**-Манай улсад агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хэдхэн компани байдаг. Өрсөлдөөн байвал тухайн салбар хөгжих нь бий. Ер нь манай улсын агаарын тээврийн зах зээлд өөр компани байгуулах орон зай хэр байна вэ?**

-Монгол Улсын агаарын тээвэр маш жижигхэн зах зээлтэй. Манай улсад дотоодын болон гадаадын нийт 7-8 компани нислэг үйлддэг. Тодруулбал, “МИАТ”, “Аэро Монголиа”, “Хүннү Эйр”, “Кориан Эйрлайнс”, Аэрофлот”, “Эйр Чайна”, “Туркиш Эйрлайнс” зэрэг компани бий. Эдгээр компани нийлээд 2012 онд анх удаа нэг сая зорчигч тээвэрлэлээ.Үүнээс орон нутгийн нислэг маш цөөхөн буюу 4000 орчим зорчигч тээвэрлэсэн. “Оюу толгой” компанийн ажилчдыг оруулаад орон нутгийн нислэгтээ дөнгөж 4000 хүрэхгүй зорчигч тээвэрлэж байна л даа. Тиймээс бид агаарын тээврийн салбараа зөв бодлогын хүрээнд хөгжүүлэх хэрэгтэй. Учир нь жижиг зах зээл хэлбэлзэхдээ маш амархан байдаг. Мөн манай улсын дотоодын компаниудын хүчин чадал хангалттай бус.“МИАТ” компани гэхэд л өөрийн нэг, түрээсийн дөрвөн онгоцтой. “Аэро Монголиа” хоёр ширхэг Покер-50 онгоцтой, “Хүннү Эйр” бас хоёр Покер-50 болон ATR-72 онгоцтой. Эндээс харахад дотоодын нислэгийн компаниуд маань парк, хүчин чадлын хувьд дэлхийн хэмжээнд өрсөлдөх боломжгүй. Тиймээс энэ тал дээр зөв бодлого баримтлах ёстой. Бидэнтэй өрсөлдөж байгаа авиа компаниуд дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг. “Кориан Эйрлайнс”, “Аэрофлот”, “Эйр Чайна”, “Туркиш Эйрлайнс” бүгд дэлхийд эхний 10 дугаарт ордог авиа компани. Манай улсын хувьд агаарын тээврийн салбараа маш бодлоготойгоор хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарсан.

**-Салбар яамнаас агаарын тээврийг хөгжүүлэх тал дээр баримталж буй бодлого сонирхол татаж байна. Ялангуяа үндэсний компаниа дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц болгоход ямар бодлого баримтлах вэ?**

- Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичигт “Монгол Улс нь үндэсний агаарын тээвэрлэгчтэй байна” гэж заасан. Энэ дагуу бид 2014 онд “МИАТ” ТӨХК-д үндэсний агаарын тээвэрлэгч гэсэн статус олгосон. Агаарын тээвэр өндөр хөгжсөн улс орнууд өөрсдийн үндэсний агаарын тээвэрлэгчийг төрөөсөө дэмжин бойжуулж дэлхийд гаргаж ирснээр агаарын тээврийн хөгжил нь эрчимжсэн тохиолдол олон бий. Сингапур улсын “Сингапур эйрлайнз” авиа компани гэхэд бүс нутагтаа төдийгүй дэлхийд тэргүүлэгч компани болон хөгжсөн. Тиймээс Монгол Улсын Засгийн газраас “МИАТ” компанийг үндэсний агаарын тээвэрлэгч гэсэн статус болгож, төрийн бодлогоор дэмжихээр шийдвэрлэсэн юм. Бид үндэсний компанийг хөгжүүлэх ажлын хүрээнд “МИАТ” компанийн парк шинэчлэлд анхаарал хандуулж, шийдвэрлэгдэж чадалгүй хүлээгдэж байсан шинэ онгоц авах хөрөнгийн асуудлыг шуурхай шийдвэрлэж чадсанаар манай улс өөрийн хөрөнгөөр худалдан авч буй том оврын эхний онгоцоо 2013 оны тавдугаар сард хүлээн авсан юм. Мөн МИАТ компани өмнө нь агаарын хөлгийн шатахуунаа зөвхөн ОХУ-аас импортоор авдаг байсан. Салбар яамнаас онгоцны шатахууны нийлүүлэлтийг олон эх үүсвэртэй болгохоор шийдвэрлэж, шатахууны хомсдолоос сэргийлэх зарим арга хэмжээ авсан. Түүнчлэн 2013 оноос эхлэн үндэсний агаарын тээвэрлэгчээ дэмжиж, Засгийн газар, яам, агентлаг, төрийн өмчийн үйлдвэрийн газар гэх мэт төрийн бүх шатны байгууллагын ажилтнууд төсвийн болон байгууллагынхаа зардлаар гадаад улсад албан томилолтоор агаарын тээврийн компаниар зорчих тохиолдолд “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр зорчиж байх үүрэг өгсөн. Салбар яамнаас үндэсний нислэгийн компаниа бодлоготойгоор дэмжиж, дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц үндэсний компани болгохын төлөө ажиллаж байна.

**-Орон нутгийн нислэгийн зорчигч бага гэлээ. Энэ нь нийслэл дэх хүн амын нягтаршил, нислэгийн үнэтэй холбоотой байх?**

-“Аэро Монголиа”, “Хүннү Эйр” компани ээжлэн орон нутгийн чиглэлд нислэг үйлдэж байна. Манай улсад сүүлийн дөрвөн жилд авто замын салбар эрчимтэй хөгжлөө. Баруун таван аймаг, зүүн аймгууд руу гурав, дөрөв хоног явж хүрдэг цаг ард үлдсэн. Одоо машинаар 6-7 цаг яваад хүрч байна. Энэ нь нэг талаараа агаарын тээврийн зорчигчид авто тээврийн хэрэгслийг сонгох нэг шалтгаан болсон. Үүнээс болж нислэгтэй зарим аймгууд нислэгээ зогсооход хүргэсэн. Мөн агаарын тээвэр болон авто тээврийн салбарын үнэ харилцан адилгүй байдаг. Улаанбаатараас Өмнөговийн чиглэлд авто тээвэр 30 мянган төгрөг байхад агаарын тээвэр 120 мянган төгрөгийн өртөгтэй. Гэхдээ агаарын тээвэр илүү бага цаг зарцуулна л даа. Ойролцоогоор дөрвөн цаг ниснэ. Хугацааны хувьд хоёр дахин бага цаг зарцуулж байгаа ч үнийн хувьд 2-4 дахин илүү өртөгтэй. Тиймээс бид агаарын тээврийн дотоодын нислэгийн тэнцвэртэй байдлыг хангах, орон нутгийн зочигчдыг нэмэгдүүлэхийн тулд зарим аймгийн чиглэлд төрөөс татаас олгох зарчмаар нислэг үйлдүүлж байна. Мөн хоёр аймгийн дунд нислэг үйлдэх, зарим нислэгт авиа компаниуд тодорхой хэмжээний үнийн хөнгөлөлт зорчигдод үзүүлэх зэрэг ажлыг зохион байгууллаа.





# ОНЦЛОХ ХУУДАС

Õýí íü õýí áý?



# НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРТ ТУРШЛАГА ДУТАХ САЙД

О.УЯНГА

“Хэн нь хэн бэ” булангийнхаа энэ удаагийн дугаарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярыг онцолж байна.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

...Хөдөлмөр, нийгмийн хамгаалал гэдэг том салбар. Тэр дундаа Монгол Улсын хамгийн эмзэг, хэцүү салбар юм. Гэтэл МАН ийм том, хэцүү салбарт ямар ч туршлагагүй хүнийг сайдаар томилчихлоо. Яг үнэндээ Н.Номтойбаяр битгий хэл туршлагатай хүн энэ салбарт жижигдэхээр шүү дээ. Манай улсад тогтвортой ажлын байртай байж, баталгаатай хөдөлмөр эрхлэхэд хэцүү. Нийгмийн хамгааллын тогтолцоо нь өөрөө эмзэг...

## Хамгийн их хэл аманд орооцолдсон сайд

2016 оны сонгуулиар МАН үнэмлэхүй ялалт байгуулж, Засгийн газраа байгуулах эрхтэй болсон. Олон хүн Засгийн газарт туршлагатай хүмүүс орж ажиллаж, мэргэжлийн Засгийн газар байгуулна гэж харж байсан ч асуудал 360 градус эргэсэн билээ. Өөрөөр хэлбэл, Засгийн газар мэргэжлийн бус, албан тушаалын наймаачдаар дүүрлээ гэж шүүмжлүүлэхээр хүмүүсээс бүрдсэн. Тэр дундаа хамгийн их хэл аманд орооцолдсон сайд нь Н.Номтойбаяр. Засгийн газар бүрдэх гэж байхад л түүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын суудлыг авахаар намынхантайгаа тохиролцсон. Сонгуулийн үеэр намдаа хамгийн их хандив өгсөн учраас шагналд нь сайдын суудал авч байна гэж олон хэвлэлээр бичсэн. Тэр ч ёсоор болж сайдын суудалд сууж чадсан.

Энэ мэтээр сайд болохдоо л элдэв хардлагад өртөж, хэл аманд орооцолдсон. Дээрээс нь өнгөрсөн дөрвөн жилд зүүсэн муу нэр нь одоо болтол дагаж яваа. “Киви” гэдэг хамтлагийн дуучин бүсгүйтэй орооцолдсон, машин авч өгсөн. Бүр өөрийнхөө машины дугаартай адилхан дугаар авч өгч хосолсныг нь шар сайтууд шүүрэн авч, ач холбогдол өгөн бичиж байгаа. Гэх мэтээр хамгийн их хэл аманд орооцолдсон сайд. Хүн амьтантай зодолдсон энэ тэр гээд янз бүрийн асуудлыг нь түүгээд бичвэл барагдахгүй их. Уг нь төрийн түшээ, сайд хүмүүс хоёрын хооронд авгай хүүхэн, зодоон цохионы хэл амнаас хол байвал зүгээрсэнж. Одоо тэрбээр сайд болсон юм чинь ирэх дөрвөн жилд ихэд төлөвших биз ээ.

## Нийгмийн хамгааллын салбарт туршлага дутна...

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал гэдэг том салбар. Тэр дундаа Монгол Улсын хамгийн эмзэг, хэцүү салбар юм. Гэтэл МАН ийм том, хэцүү салбарт ямар ч туршлагагүй хүнийг сайдаар томилчихлоо. Яг үнэндээ Н.Номтойбаяр битгий хэл туршлагатай хүн энэ салбарт жижигдэхээр шүү дээ. Манай улсад тогтвортой ажлын байртай байж, баталгаатай хөдөлмөр эрхлэхэд хэцүү. Нийгмийн хамгааллын тогтолцоо нь өөрөө эмзэг. Нийгмийн даатгал нь ч, нийгмийн халамж нь ч хэцүүхэн байгаа. Гэтэл Н.Номтойбаяр сайд энэ бүх асуудлын сул талыг хараад, иргэддээ хэрэгтэй бодлого хэрэгжүүлээд, шийдээд явахад арай л туршлага дутах болов уу. Мань хүн 1997-2001 онд АНУ-ын Индиана мужийн Валпарайсо Их Сургууль Улс төрийн шинжлэх ухаан, Практик бизнесийн хос мэргэжлээр суралцаж төгссөн. Гадаадад сургууль төгссөн гэдэг утгаараа боловсролоор дутаад байх юмгүй л байх. Гэхдээ энэ салбарт улс төрийн шинжлэх ухаан судалсан хүн хэрэггүй шүү дээ. Яах вэ, өмнө нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайдаар ажиллаж байсан болохоор бага зэрэг ойлголттой гэж зүтгэж болох юм.

Гэхдээ л энэ салбарт Монгол Улсын нийгмийн хамгааллын нөхцөл байдал, хөдөлмөрлөх орчин гээд бүхий л зүйлийг хардаг, онцлогийг нь мэдэрдэг, ёстой л мэргэжлийн хүн ажиллавал дээр байсан юм. Н.Номтойбаяр сайд МАК компанид дарга хийж байсан болохоор энэ бүх асуудлыг мэдэрнэ гэж зүтгэдэггүй л юм бол ядуу хүний зовлонг ойлготол бас ч гэж хол байна даа. Мөн нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэх зайлшгүй шаардлага манай улсад бий. Яг үнэндээ халамжийг хавтгайруулаад, хэнд ч хамаагүй мөнгө өгөөд байгаа шүү дээ, манай улс. Сүүлийн хэдэн жилд арай дээр болж байгаа ч гэсэн хавтгайрсан халамж танагдаагүй л байна. Өнөөдөр цоо эрүүл, ажил төрөлтэй мөртлөө автобусанд хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэхээр зорчиж байгаа хэчнээн хүн байдаг билээ дээ. Гэх мэтээр тоочоод байвал маш их зүйл байна. Энэ бүхнийг ойлгож, харж, шийдэх чадвар түүнд бий бил үү.

## Хөдөлмөрчид хохирч, нийгмийн халамж хүрсэн төвшнөөс буурчээ

Н.Номтойбаяр сайдын үед хөдөлмөрчид хохирч, нийгмийн халамж хүрсэн төвшнөөсөө буурчихаад байна. Нийгмийн даатгалтай холбоотой гэвэл “Хамтын тэтгэвэр”-ийн хуулийг хүчингүй болголоо. Насаараа нийгмийн даатгал төлсөн хүн тэтгэвэрт гарч чадалгүй нас барах тохиолдол маш их бий. Тэгвэл ардны үлдэж хоцорсон хань ижил тодорхой хэмжээнд тэтгэврийг нь авч болохоор байсныг өөрчилсөн. Өнөөдөр нэг нам солигдоод л төрийн албан хаагчид хэдэн мянгаараа ажилгүй болж байна. Салбар болгонд ажлаасаа халагдсан хүмүүс дүүрлээ. Хөдөлмөрийн сайд юу хийв, тэдний оронд намынхаа хүмүүсийг авч байгааг нь хөдөлмөрчдийн асуудлыг шийдсэн л гэхгүй бол өөрөөр өмөөрөх юм алга. Хэдийгээр МАН-ын Засгийн газраас явуулж байгаа бодлого байж болох ч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын оролцоо ч бас байгаа. Нийгмийн халамжийн хувьд хүрсэн төвшнөөсөө эрс буурчихсан. Төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахдаа авдаг байсан 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг алга болгочихлоо. Хүүхдийн мөнгийг ялгавартай олгож байна. Оюутны 70 мянгыг ч гэсэн ялгаж олгож байгаа. Хоёрхон хоногийн өмнө 70 мянгаас гадуурхагдсан МСҮТ-ийн оюутнууд жагсаал зохион байгуулж байна. Угаасаа их, дээд сургуулийн оюутнуудад олгочихоод МСҮТ-ийнхнийг ялгахаар аргагүй шүү дээ. Ийм л сонгуульжсан бодлогыг салбарын сайд нь барьж байна. Ийм байхад Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар хөгжих үү. Өнөөдөр залуучууд ялгаварлалаа гэж жагсч байна. Маргааш багш, эмч нар ажил хаяад жагсвал яах вэ. Угаасаа насаараа ажилчихаад нэг сайдын үзэмжээр тэтгэмж авахын төлөө багш, эмч хийгээд явах хүн олдох уу. Энэ асуудлыг бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд эргэж харах л ёстой. Монголд төрийн алба гэдэг, тэр дундаа багш, эмч нар маш хүнд хөдөлмөр эрхэлж байгаа. Ядаж байхад цалин мөнгө нь муу. Нийгмийн асуудлаа шийдвэрлэх ямар ч боломж байхгүй. Ганц шийдэл нь 36 сарын тэтгэмж байсан. Гэтэл түүнийг нь “хүртэл” гэдэг ганц үгээр л үгүй хийчихсэн. Ийм байвал хэн багш, эмч хийх юм бэ. Дээрээс нь хүүхдийн мөнгөө өгч чадахгүй ялгаварлаж байж юун “Цалинтай ээж” яриад байгааг ойлгохоо болилоо.

Өнөөдөр Монгол Улсад хүн амыг өсгөхөд чиглэсэн бодлого тун хэрэгтэй байгаа. Өмнө нь гурав дахь хүүхдийн бодлого хэрэгжүүлнэ гэж их ярьсан. Гэвч ажил хэрэг болгоогүй. Харин өнөөдөр 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхэд цалин өгөх асуудал яриад явчихлаа. Тэр мөнгө нь хаана ч байгаа юм. Хүүхдийн мөнгөө өгч чадахгүй төр ирэх оны эхнээс эхчүүдэд цалин өгч чадах уу. Гэх мэтээр олон асуудал байна. Энэ бүхнийг шийдчих чадвал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад байна уу гэвэл бас л эргэлзээтэй. Хамгийн хэцүүхэн салбарыг хариуцах сайдын ажлаа авснаас хойш хийсэн дорвитой ажил нь юу вэ. “Цалинтай ээж”-тэй хамааруулбал хамааруулж болох юм. Түүнээс өөрөөр энэ салбарт одоогоор гэгээтэй юм алга. Өдөр ирэх тусам хүмүүс ажилгүй болж, ядуурч, хэцүүдэж л байх шиг байна.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ДЭЛХИЙ

## Жулиан Ассанжийн интернэт сүлжээг хязгаарлажээ

Эквадор улсын Засгийн газар Их Британийн Лондон дахь тус улсын Элчин сайдын яаманд орогнож буй "Викиликс" сайтыг үүсгэн байгуулагч Жулиан Ассанжийн интернэт сүлжээг түр хугацаанд тасалсан тухайгаа албан ёсоор мэдээлсэн байна. Тэд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд шууд нөлөөлж болзошгүй мэдээлэл баримтыг Викиликс сайт олон нийтэд дамжуулахаас урьдчилан сэргийлэх үүднээс уг арга хэмжээг авчээ. "Викиликс" сайт ойрын хэдэн долоо хоногийн турш Ардчилсан намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Хиллари Клинтоны алдагдсан их хэмжээний хувийн емэйлийг олон нийтэд дэлгэж байсан юм. Ингэснээр ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг тус сайтын дэлгэсэн мэдээлэл эсрэгээр Бүгд найрамдах намаас нэр дэвшигч Доналд Трампад ашигтайгаар эргэж буйг Хилларигийн сонгуулийн штабаас мэдэгдэж, удаа дараа эсэргүүцэж буйгаа илэрхийлж байлаа. Тэгвэл уг үйл явдлын дараахан түүний интернэт сүлжээг тасалжээ. Үүнтэй холбогдуулан Эквадор улсын Гадаад хэргийн яам ч мэдэгдэл гаргажээ. Тэрхүү мэдэгдэлдээ "Эквадор улсын Засгийн газар өөр бусад улс орны дотоод асуудалд үл оролцох зарчмыг хүндэтгэдэг. Манай Засгийн газрын хувьд хилийн чанадад болж буй сонгуулийн үйл явцад саад учруулахгүй бөгөөд аль нэг нэр дэвшигчийг дэмждэггүй болно. Тиймээс түр хугацаанд Элчин сайдын яамны харилцаа холбоог хязгаарлах шийдвэр гаргасан" гэх тайлбарыг хийсэн юм. "Викиликс" сайт энэ сарын 17-нд Жулиан Ассанжын интернэт сүлжээг тасалсан Эквадор улсын Засгийн газрыг буруушаасан мэдэгдлийг хийж байв. Улмаар АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жонн Керригийн заавраар хийсэн гэх байр суурийг илэрхийлж байлаа. Гэвч албаныхан эрс үгүйсгэсэн юм.

# Хэт даврагчид Мосулыг алдвал, Европ руу халдана



Б.ДАВААХҮҮ

Иракийн арми өнгөрсөн оны зургадугаар сараас хойш хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн хяналтад орсон тус улсын хоёр дахь том хот гэгддэг Мосул хотыг чөлөөлөх дайралтаа эхлүүлсэн билээ. Мосул хот нь Ирак дахь террористуудын хамгийн гол түшиц цэг нь бөгөөд армийнхан энэ дайнд ялалт байгуулж, хотыг чөлөөлснөөр "Лалын улс" бүлэглэл бүрмөсөн ялагдал хүлээх боломжтой гэж албаныхан тооцсон байдаг. Улмаар

> ...Мосул хотыг хянаж буй террористууд бүгд Европ руу дайжих магадлал хэдийгээр бага байгаа ч, цөөн тооны алан хядагчийн учруулж болох харгислалд бэлтгэлтэй байх шаардлагатайг онцолжээ...

АНУ тэргүүтэй холбоотон улсын цэргийн армийн дэмжлэгтэйгээр Мосул хотын өмнөд болон зүүн хэсгээс нь давшиж эхэлснийг Иракийн Ерөнхий сайд өмнө нь мэдээлж байв. Тэгвэл энэ дайнд Иракийн арми ялсан тохиолдолд хэт даврагч бүлэглэлийнхэн Европын аль нэг улс руу давшиж, гэм зэмгүй иргэдэд аюул учруулж болзошгүйг зарим ажиглагчид анхааруулллаа. Сүүлийн хоёр жилийн хугацаанд Европын хэдэн мянган залуус Ирак, Сири рүү явж, хэт даврагч бүлэглэлд элссэн гэх мэдээлэл бий. Гэвч энэ он гарснаас хойш дээрх хоёр орон дахь террористуудын хяналт дахь бүс нутгийн хэмжээ мэдэгдэхүйц багассанаар тэдгээр жихадуудын зарим нь Европ руугаа буцаж эхэлсэн байна. Иймээс нутаг буцсан алан хядагчид Европт халдлага үйлдэх эрсдэлтэйг хэд хэдэн нөлөө бүхий ажиглагчид анхааруулж байгаа юм. Евро комиссын гишүүн Жулиан Кинг Германы "Диэ Уэлт" гэх сонинд өгсөн ярилцлагадаа Мосул хотыг чөлөөлөх дайралт амжилт олсон тохиолдолд "Харгис террористууд Европт эргэн ирэх нь гарцаагүй" гэх байр суурийг баримталж буйгаа илэрхийлсэн байна.

Гэхдээ Мосул хотыг хянаж буй террористууд бүгд Европ руу дайжих магадлал хэдийгээр бага байгаа ч, цөөн тооны алан хядагчийн учруулж болох харгислалд бэлтгэлтэй байх шаардлагатайг онцолжээ.

Түүний үзэж буйгаар Ирак, Сирийн нутагт байрлаж буй Европоос гаралтай жихадуудын тоо аль хэдийнэ 2500-д хүрсэн гэнэ. Мөн Их Британийн Батлан хамгаалах, аюулгүй байдлын хүрээлэнгийн Олон улсын аюулгүй байдал хариуцсан ахлах Раффаэлло Пантуччи "ДэйлиТелеграф" сонинд нийтлүүлсэн бичвэртээ "Лалын улс" бүлэглэл Ирак дахь хамгийн гол түшиц цэг болох Мосул хотыг алдсан тохиолдолд барууны орнуудад заналхийлж болзошгүйг сэрэмжлүүлсэн байв. Тэрбээр "Удирдагчгүй хувьсгал хийх хүсэл эрмэлзлэлээ алдсан жихадууд цаашдаа дэлхийн аль нэг улсын аюулгүйн албаныхныг сүрдүүлж болзошгүй" хэмээсэн байгаа юм. Үүнээс гадна терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулах Ірpso компанийн мэргэжилтэн Крис Филиппс ч хэт даврагч бүлэглэл ялагдал хүлээсэн тохиолдолд шинэ газар нутагт аюул учруулах магадлалтайг сануулжээ.

## "Шүхэрт хувьсгал"-ынхны тангараг өргөх ёслолыг бойкотлов

Хонконгийн парламентад өчигдөр зарим гишүүдийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулагджээ. Улмаар Хятадаас тусгаар тогтнохыг дэмжигч, "Шүхэрт хувьсгалчид"-аас гаралтай хоёр залуу гишүүний тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг зарим гишүүд бойкотложээ. Хонконгийн парламентын гишүүд өнгөрсөн долоо хоногт тангарагаа өргөж эхэлсэн хэдий ч, тухайн үед хоёр залуу гишүүн "Хонконг бол Хятад биш" гэх үгийг бичсэн шар өнгийн лоозонг барьж эсэргүүцлээ илэрхийлснээр энэ үйл ажиллагаа тасалдсан аж. Тиймээс өчигдөр дахин тангараг өргөх үйл ажиллагааг зохион байгуулж, тусгаар тогтнолыг дэмжигч залуус гишүүний тангарагаа өргөх ёстой байсан гэнэ. Гэвч мөн л Хятадын талыг баримтлагч гишүүд эсэргүүцэл илэрхийлж, уг үйл ажиллагааг бойкотлосноор Хонконгийн парламентад дахин эмх замбараагүй байдал үүсчээ. Тангарагт Хонконг бол БНХАУ-ын тусгай засаг захиргааны нэгж гэх үгийг бичсэн байдаг аж. Гэвч хоёр залуу гишүүн Хятад улсын нэрийг зориуд буруу дуудсан гэнэ. Тэдний нэг нь "БНХАУ" гэж хэлэх ёстой үгийг "the People's refucking of Zeena" гэж хэлжээ. Үүний улмаас Хятадын талыг баримтлагч гишүүд ирцийг бүрдүүлэхгүйн тулд санаатайгаар ёслолыг орхин гарснаар, танхимын гадна Хятадын талыг баримтлагч болон Ардчиллыг дэмжигч гишүүд хоорондоо маргалдаж, эмх замбараагүй байдал үүсгэжээ. Улмаар эцэстээ "Шүхэрт хувьсгал"-аас гаралтай хоёр залуу гишүүн өчигдөр мөн л тангарагаа өргөж чадалгүй, дахин хойшлуулахад хүрсэн байна. Өнгөрөгч есдүгээр сард Хонконгийн Хууль тогтоох зөвлөлийн сонгууль болсон бөгөөд энэ сонгуульд ардчиллыг дэмжигч "Шүхэрт хувьсгал"-ын хоёр төлөөлөл иргэдийн итгэлийг хүлээж, ялалт байгуулсан юм. Гэвч тэд үзэл суртлынхаа улмаас тангарагаа өргөж чадалгүй, энэ мэт эмх замбараагүй байдал үүссээр байна.

## Доналд Трампын тухай кино хийжээ

АНУ-ын экс Ерөнхийлөгч Жорж Вашингтон Бушийг шүүмжилсэн утга агуулга бүхий "Fahrenheit 9/11" баримтат киног бүтээж байсан найруулагч Майкл Мур ирэх сард болох АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвшиж буй Доналд Трампын тухай дэлгэцийн бүтээл туурвижээ. Улмаар Нью-Йорк хотын IFC театрт өчигдрөөс эхлэн үнэ төлбөргүйгээр гаргаж эхэлсэн байна. Найруулагч киноны талаар өөрийн твиттер хуудсаараа дамжуулан олон нийтэд зарласан бөгөөд киноны нэр нь "Michael Moore in Trump Land" гэнэ. Харин агуулгын тухайд Охио мужийн тайзан дээр шоу хийж буй нэгэн эрийн тухай өгүүлэгдэх бололтой. Найруулагч Майкл Мур хэт зүүний үзэл баримтлалт улстөрч гэдгээрээ мөн алдартай бөгөөд Трампыг удаа дараа шүүмжилж ирсэн байдаг. Тиймээс ч уг киногоо үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эр Бүгд найрамдах намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээ урьдчилан мэдэж байсан гэх сэдвээр бүтээжээ. Найруулагчийн хувьд Ардчилсан намаас нэр дэвшигч Берни Сандерсыг дэмжиж байсан гэдэг. Гэвч, тус намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон нэр дэвшиж буй билээ. Майкл Мур Нью-Йоркоос сенатад сууж байх үед буюу 2003 онд Иракийн дайныг дэмжсэн гэдэг утгаар нь Хиллари Клинтоныг дэмждэггүй гэнэ.

## Саудын Араб улсын ханхүүгээ цаазаллаа

Саудын Арабын эрх бүхий байгууллага хүн амины хэргээр цаазын ял сонссон улсын угсаа залгамжлах ханхүү Турки Бин Сауд ал Кабирын ялыг гүйцэлдүүлснээ мэдэгдлээ. Саудын Арабын хааны гэр бүлийн гишүүд хэдэн мянгаар тоологдох хэдий ч, хэн нэгэн нь цаазлуулсан тохиолдол өмнө нь гарч байгаагүй аж.
Тус улсын Хууль зүйн яамнаас мэдээлснээр Кабир ханхүүг өөртэй нь муудалцсан хүнийг өчиггүй буудан хороосон гэх үндэслэлээр нийслэл Рияад хотын шоронд ялыг гүйцэлдүүлсэн байна. Хэргийг эргэн сануулбал, 2014 оны арваннэгдүгээр сард Рияад хотын шүүх бүрэлдэхүүн найзыгаа хэрцгийгээр хөнөөсөн гэх үндэслэлээр ханхүү Турки Бин Сауд ал Кабирт цаазаар авах ял ногдуулж байлаа. Эх сурвалжийн өгүүлснээр Ханхүү 2012 онд Рияад хотын захад байрлах амралтын газарт нэгэн найзтайгаа муудалцаж, улмаар буудан хөнөөж, мөн нэг хүнийг шархдуулсан байдаг аж. Түүнчлэн, хэргээ өөрөө цагдаад мэдүүлж байжээ. Саудын Арабт цаазын ялыг ихэнхдээ хоолойг нь хэрчих маягаар гүйцэтгэдэг байна. Ямартай ч, ханхүү Турки Бин Сауд ал Кабир энэ он гарсаар цаазаар авхуулсан 134 дэх хүн болж байгаа аж.



# ШУУРХАЙ МЭДЭЭ

## АЗЗА-ЫН КОМПАНИУД ЦАСНААС ХАМГААЛАХ ДАЛАНГАА ХИЙЖ ДУУСЧ БАЙНА

Н.БАТЗАЯА

*Зам тээврийн хөгжлийн төвийн Замын хяналтын хэлтсийн мэргэжилтэн Б.Эрдэнэцэцэгээс орон нутаг дахь замын нөхцөл байдлын талаар зарим зүйлийг тодрууллаа.*

**-Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс хөдөө орон нутагт цас орно гэж анхааруулж байна. Замын нөхцөл байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Ойрын хугацаанд цаг агаарын нөхцөл байдлаас хамаарч, даваа гүвээ цасанд боогдох, хальтиргаа гулгаа үүсэх тохиолдол гарсан. Гэхдээ энэ бүхэнд манай АЗЗА-ын компанийн ажилчид шуурхай арга хэмжээ авч ажиллаж байна. Цаашид ихэнх аймгийн нутгаар цас орно гэдгийг ус, цаг уурын хүрээлэнгээс анхааруулсан. Одоогийн байдлаар Дархан-Уул аймгийн А0401 чиглэл буюу Төв аймгийн Баянчандмань сумаас цааш цас орсон. Мөн А0402 буюу Дархан-Уул аймгаас Сүхбаатар аймгийн замд нилээхүйдээ цас орсон байдалтай байна. Энэ үеэр Дархан болон Сэлэнгэ аймгийн авто замын засвар, арчилгааны компанийн ажилчид шуурхай арга хэмжээ авч ажилласны үр дүнд замын хөдөлгөөнд ямар нэгэн саад учраагүй. Замын хөдөлгөөн хэвийн үргэлжилж, хальтиргаа, гулгаа багассан. Мөн зүүн аймгийн нутагт хур тунадас харьцангуй бага унасан. Дорнод аймагт бага зэргийн цас орсон. Гэхдээ хальтиргаа, гулгаа үүсэх хэмжээнд хүртэл ороогүй. Өнөөдрийн байдлаар хөдөө орон нутгийн замын нөхцөл байдал хэвийн байна. Цас орсон газруудад АЗЗА-ын компанийн ажилчид шуурхай арга хэмжээ авсан.

> ...Улсын хэмжээнд нийт 28 автозам засвар, арчлалтын компани үйл ажиллагаа эрхэлдэг. АЗЗА-ийн компаниуд цаснаас хамгаалах далан, элс хайргаа нөөцөлж дуусч байна. Манайд сар бүрийн 25-нд АЗЗА-ын компаниуд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийн тайлангаа явуулдаг...

**-Дархан-Уул аймгийн замыг хаасан гэж байсан. Нээсэн үү?**

-Тийм. "Дархан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн хариуцсан А0402 дугаартай Дархан-Сүхбаатар чиглэлийн замд өнгөрсөн мягмар гарагт гулгаа үүссэн. Үүнтэй холбогдуулан тус аймгийн Онцгой байдлын газраас замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хаасан юм билээ. Жолооч болон иргэдийн аюулгүй байдал, осол гарахаас сэргийлж урьдчилсан арга хэмжээ авч ажилласан. Дархан-Сүхбаатар чиглэлийн зам хэвийн ажиллаж эхэлсэн. Ер нь бусад нутгаар хур тундасгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн чөлөөтэй зорчиж байна.

**-Өнгөрсөн хоногт орсон цасны үеэр АЗЗА-ын компаниуд ямар зохион байгуулалттай ажиллав?**

-Сэлэнгэ аймгийн А0402 дугаар замын чиглэлд цас орсон. Тус аймгийн "АЗЗА" ТӨХК-ийн ажилчид Арангат, Ерөө, Хар морьтын даваанд гулгаа үүсэхээс сэргийлж нэг ачигч, нэг өөрөө буулгагч, нэг үйлчилгээний машин техниктэйгээр нийт зургаан хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Мөн "Булган АЗЗА" ТӨХК-ийн хариуцсан А1002, Дархан-Эрдэнэт, А0902 Булган-Мөрөн чиглэлүүдэд цас орж ажлын хэсэг гарч ажиллаж дууссан. "Баянчандмань АЗЗА" ТӨХК-ийн хариуцсан А0401 буюу УБ-Дархан чиглэлд цас орж, шуурхай арга хэмжээ авч, замын хөдөлгөөн саадгүй болсон.

**-Автозам засвар, арчлалтын компаниуд өвлийн бэлтгэл ажлаа хангасан уу?**

-Улсын хэмжээнд нийт 28 автозам засвар, арчлалтын компани үйл ажиллагаа эрхэлдэг. АЗЗА-ийн компаниуд цаснаас хамгаалах далан, элс хайргаа нөөцөлж дуусч байна. Манайд сар бүрийн 25-нд АЗЗА-ын компаниуд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийн тайлангаа явуулдаг. Элсэн овоолго, цаснаас хамгаалах далангаа хийж дууссан гэж ойлгож болно.

**-Хөдөө орон нутаг руу явах жолооч нар байгаа байх. Жолооч нар юуг анхаарах хэрэгтэй вэ?**

-Цаашид цас орж, орон нутгийн замд хальтиргаа гулгаа үүсч, замын гадаргууд мөсөн бүрхүүл тогтож болзошгүй тул жолооч нар автомашиныхаа аюулгүй байдлыг хангаж, болгоомжтой зорчихыг анхааруулж байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ЦАС ОРЖ, САЛХИ ШИРҮҮСНЭ

Өнөөдөр нутгийн хойд хэсгээр цас орж, ихэнх нутгаар салхи шуургатай байх тул халтиргаа гулгаа үүсч зам даваа хаагдаж болзошгүйг анхааруулж байна. Тодруулбал, 21, 22-нд зарим газраар, 23-нд баруун болон төвийн аймгуудын нутгаар, 24-нд ихэнх нутгаар цас орно. Салхи 21, 22-нд Алтайн уулс, Арц Богдын өвөр хоолойгоор секундэд 12-14 метр, 23-нд баруун аймгуудын нутгаар, 24-нд ихэнх нутгаар секундэд түр зуур 18-20 метр хүрч цасан болон шороон шуурга шуурна. Ихэнх хугацаанд Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна. 24-нд нутгийн баруун хагаст хүйтэрнэ.

## Улаанбаатар хотод "Ногоон барилга" барих санал тавьжээ

Нийслэлийн Засаг дарга С.Батболд өнгөрсөн мягмар гарагт Олон улсын санхүүгийн корпарацийн Филиппин улс дахь Ерөнхий хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Жессе Ангийг хүлээн авч уулзжээ. Уулзалтаар Улаанбаатар хотын эко хөгжлийн бодлого, эрчим хүчний дэд бүтцийн бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх, тодорхой төслүүд буюу нийслэлийн гэр хорооллыг өртөг багатай, хямд орон сууцаар хангах тал дээр санхүүгийн төлөвлөлт хийх, Улаанбаатар хотын дэд төвүүдэд иргэдийн орлогод нийцсэн орон сууц барих төсөл хэрэгжүүлэх боломжийг талаар харилцан ярилцсан байна. Энэ үеэр Филиппин улс дахь Ерөнхий хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Жессе Анг "Ногоон барилга"-ын төслийг Ази тив болон Латин Америкийн улсуудад хэрэгжүүлдэгээ хэлээд, Монгол Улстай энэ тал дээр хамтран ажиллах сонирхолтой байгаа илэрхийлсэн байна. Үүнтэй холбоотойгоор Нийслэлийн Засаг дарга С.Батболд "Манай улсын сэрүүний улирал урт учраас барьж байгаа барилгын дулаан алдалтын тал дээр анхааран ажиллах хэрэгтэй байгаа. Манайд ногоон барилгын ажлыг эхлүүлэхийн тулд Үндэсний хэмжээний стандарт боловсруулахаас эхлээд нэлээдгүй ажил төлөвлөхийг хэлээд "Ногоон барилга" төслийг хэрэгжүүлэхэд Улаанбаатар хотын зүгээс татгалзах зүйл байхгүй" гэв. Дашрамд, энэхүү ногоон барилга нь эрчим хүчний болон усны зарцуулалтад асар их эдийн засгийн хэмнэлтийг мэдрүүлдэг гэж Филиппин улс дахь Ерөнхий хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Жессе Анг уулзалтын үеэр онцлон хэлжээ.

## Галт тэрэгний хөдөлгөөнд саад учруулсан жолоочийг шалгаж байна

Төмөр замын цагдаагийн газраас галт тэрэгний хөдөлгөөнд саад учруулсан жолоочийн зөрчлийг шалгаж байна. Энэ сарын 17-нд Замын цагдаагийн баруун урд уулзвараас Баянмонгол хорооллын уулзвар хүртэлх авто зам болон төмөр замын огтлолцолд зам түгжрэн, нэг машин галт тэрэгний гарамыг хааж зогссон. Улмаар хөдөлгөөн эхлүүлсэн галт тэрэгний машинист яаралтай арга хэмжээ авч, вагоноо зогсоосон юм. Энэхүү үйлдэл нь иргэний эд хөрөнгө цаашлаад амь насанд хохирол учруулах магадлалтай нөхцөл байдал үүссэн байсныг галт тэрэгний машинист шуурхай арга хэмжээ авч болзошгүй үйлдлийг таслан зогсоосон юм. Тухайн үед холоос ирж буй галт тэрэг хурдаа сааруулж, дохио өгсөөр гарман дээр зогсож байсан автомашинтай тулж зогссон дүр зураг тус бичлэгт бичигдсэн байсан юм. Энэ талаар бид өмнө нь мэдээллэсэн билээ. Төмөр замын аюултай бүс рүү нэвтэрч зам хааж зогссон автомашины жолоочийн буруугаас болж ийм нөхцөл байдал үүссэн байдаг. Тус хэсгээр зорчиж буй жолооч төмөр замыг заавал гарц гарамтай хэсгээр нэвтрэн, төмөр замын гарамд ойртон очихдоо аюулгүй байдал хангагдсан эсэхийг магадласан байх, дуут буюу гэрлэн дохио тэмдэг тэмдэглэлийн заалт, хаалтын байрлал, гарамын жижүүрийн заалтыг удирдлага болгоно, ямарч үед гарман дээр зогсох ёсгүй гэж замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулинд заажээ. Жолоочийн үүргээ зөрчсөн тохиолдолд дээрх хуулиар арга хэмжээ авдаг аж.

ДУУЛГАХ СОНИН




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



*МСУТ-ийн оюутнууд өнгөрсөн мягмар гарагт Тусгаар тогтнолын ордны өмнөх талбай дээр 70 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгохыг шаардан жагсаал зохион байгууллаа. Энэхүү жагсаалд Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй МСУТ-ийн оюутнууд "Тэтгэлэгээ авмаар байна" гэсэн утга бүхий лоозон барин цугласан юм.*

## Хууль бусаар хар тамхи нэвтрүүлсэн нь тогтоогдов

Эрүүгийн цагдаагийн газрын "Хар тамхитай тэмцэх хэлтэс"-ийн албахаагчид Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, Буянт-Ухаа дахь гаалийн газартай хамтран есдүгээр сарын 23-ны өдөр хар тамхи хууль бусаар нэвтрүүлсэн хоёр этгээдийг барьж, эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаах ажиллагаа явуулж байна. Шалгалтаар Монгол Улсын иргэн А, Д нар нь урьдчилан үгсэн тохиролцож, БНХАУ-ын Бээжин хотоос хар тамхи, мансууруулах бодисын төрөлд орох ICE буюу мөс гэх бодисыг их хэмжээгээр Монгол Улсын хилээр "Чингис хаан" олон улсын нисэх буудлын хилийн боомтоор хууль бусаар нэвтрүүлсэн нь эцсийн байдлаар тогтоогджээ. Тус этгээдүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 188.2, 192.2-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Холбогдогч А, Д нар нь ашиг олох зорилгоор дээрхи мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан аж. Дээрхи этгээдүүдийг ШШГЕГ-ын харьяа 461-р хорих ангид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжлүүлэн явуулж байна.

## Автозамын ослын улмаас хоёр хүн амиа алджээ

Замын цагдаагийн газрын ЖШУХ-т өнгөрсөн мягмар гарагт нийт 371 дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авснаас, зам тээврийн ослын 295 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс хоёр хүний амь нас хохирч 13 хүн хүнд хөнгөн гэмтжээ. Тодруулбал, Чингэлтэй дүүргийн нутаг Баянбүрдийн автобусны буудлын хойд талд RT.Раум маркийн авто машины жолооч Э нь явган зорчигч 30 орчим насны эрэгтэй хүнийг дайрч амь насыг нь хохироосон хэрэг гарчээ. Мөн Хөвсгөл аймгийн Чандмань өндөр сум Тайг гэх шороон замд T.Landcruser маркийн Г жолоочтой авто машин онхолдож зорчигч 51 настай эмэгтэй Ц-ийн амь хохирсон байна. Харин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 43 жолоочийг илрүүлж гарч болзошгүй осол хэргээс урьдчилан сэргийлж ажиллажээ.

# NO STRESS

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

## Б.Клинтоны нууцыг илчилсэн зураг



Б.ДАВАА

АНУ-ын “Си Эн Эн” агентлаг өнгөрсөн сарын 26-ны өдөр цахим хуудастаа бүх цаг үеийн хамгийн алдартай 25 гэрэл зургийн жагсаалтыг нийтэлсэн байв. Улмаар тэрхүү жагсаалтад багтсан нэгэн содон бүтээлийг уншигчиддаа “Дэлхийн шилдэг гэрэл зураг” буландаа сонирхуулахаар бэлдлээ. Энэ зургийг өнөөдрөөс 20 жилийн тэртээ буюу 1996 онд Вашингтонд болсон нэгэн хандивын үйл ажиллагааны үеэр авчээ.

Тухайн үед Билл Клинтон АНУ-ын Ерөнхийлөгчийн албыг хашиж байсан бөгөөд тэрбээр цагаан ордны тэргүүн болоод аль хэдийнэ гурван жилийг үдсэн байлаа. Хандивын үйл ажиллагаанд олон хүн цугларсан байх бөгөөд тэдний голд Ерөнхийлөгч Билл Клинтон, Моника Левински нар халуун дотноор тэврэлдэж байх ажээ. Тухайн үед Ерөнхийлөгч эр болоод Цагаан ордны дадлагажигч оюутан хоёрын дотно харилцаа олонд ил болоогүй байж. Тиймээс ч зургийн нарийн учир хүмүүст тун ойлгомжгүй санагдаж байжээ.

Гэсэн ч үүний дараахан Билл, Левински нар учир ургуулж явсан гэх мэдээлэл гарч эхэлсний дараа гэрэл зурагчин Дирк Холстид өөрийн архиваасаа дээрх зургийг сэргээж, “Time” сэтгүүлийн нүүрт нийтэлсэн байна. Ийнхүү Цагаан ордон дахь секс дуулиан бүр эрт эхэлсэн нь олонд илчлэгдэж, дэлхий даяар шуугиан тарьжээ. Түүнчлэн, энэ явдал АНУ-ын 42 дахь Ерөнхийлөгчийг суудлаас нь буулгах дөхсөн удаатай.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 3
Шөнө -7

Нөгөөдөр
Өдөр 5
Шөнө -8

### Өдрийн зурхай

**Намрын адаг шар нохой сарын Хөх хар мэнгэтэй Хөхөгчин гахай өдөр. Бархасбадь гараг**

**Үс засуулбал:** Өлсөж ундаасна

**Наран ургах, шингэх:** 07:22 - 18:04



*Өдрийн өнгө: Тухайн өдөр туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнэс эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, хараал, жатхыг буцаах, нялхасын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахайболой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Хяруу унах улирал 8 цаг 13 минутад эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

ДУУЛГАХ СОНИН

## УРАН НУГАРААЧ Э.АЗБИЛЭГ “Miss Earth”-д эх орноо төлөөлж байна



“Miss Earth” тэмцээн Филиппиний Манила хотод амжилттай болж байна. Байгаль орчин, эх дэлхийгээ хамгаалахыг сурталчлах зорилготой уг тэмцээнд эх орноо төлөөлөн уран нугараач, мисс Э.Азбилэг оролцож байгаа юм. Энэхүү тэмцээний ялагч “Miss Earth” тэмцээний ялагч гоо бүсгүй тухайн жилдээ байгаль орчин, экологийн болон дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцдогоороо онцлогтой. Эх дэлхийгээ хамгаалахын төлөө дуу хоолойгоо өргөж буй гоо бүсгүйн тэацээнд 80 гаруй орны мисс оролцож байгаа гэнэ. Дашрамд сонирхуулахад, энэхүү тэмцээн нь нэр хүндээрээ "Miss Universe", "Miss World", "Miss International" тэмцээний дараа бичигддэг, чансаатай ажээ. Мөн өнгөрсөн жил уг тэмцээнд Филиппиний мисс Анжилиа Габрэна түрүүлсэн байна.

## Загвар өмсөгч А.Чингүүн ГУРАВ ДАХЬ ХҮҮХДЭЭ ӨЛГИЙДӨН АВЧЭЭ

Загварын ертөнцийн дуулиант хосуудын тоонд зүй ёсоор багтсан мисс Ч.Содтуяа, загвар өмсөгч А.Чингүүн нарын дурлалын романс тэдийлэн удаан үргэлжлээгүй. Тэдний дундаас төрсөн Содонгоо хэмээх хөөрхөн охиноо мисс бүсгүй өөрийн нэрээр овоглодог бөгөөд эдүгээ АН-ын хурган даргатай ханилж яваа. Харин мисс хүүхний хайр халамжгүйг гайхсан загвар өмсөгч А.Чингүүн “Их засаг” их сургуулийн захирал Д.Ням-Осорын бага охин болох “Royal HD” телевизийн хөтлөгч Н.Ундралтай гэрлэж, Ч.Чин-Үнэн нэртэй хөөрхөн хүүгээ тэвэрсэн. Бэлтэй хадмынхаа хүчинд “Хүннү” группын тэргүүнээр ажиллаж, зочид буудлынхаа бүхий л үйл ажиллагааг цахим ертөнцөд рекламдах болсон тэрбээр ёстой л нэг жаргаж суугаагаа “гайхдаг” юм билээ.

Хуулийн чиглэлээр суралцангаа бие бялдраа хөгжүүлж, хайртай гэргийгээ үргэлж баярлуулахыг хичээдэг гэх А.Чингүүн саяхан гэр бүлийн шинэхэн гишүүнээ өлгийдөн авчээ. Энэ тухайгаа тэрбээр “Эхнэртээ баярлалаа. 3, 700 килограмм маматай боллоо. Баярлалаа, хайр аа” хэмээн сэтгэл догдлон бичсэн бөгөөд одоогоор шинэ төрсөн хүүхдийнхээ хүйсийг ихэд нууцалж байгаа гэнэ. Ямартай ч, загвар өмсөгч А.Билгүүн гурав дахь хүүхдээ өлгийдөн авсан нь энэ юм.

### Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Han Tengeriin Nar**

Автобус гэснээс нэг юм санаанд орчихлоо. Аав автобус баазад ажилладаг байв. Ээж юм оёод л. Нэг намар охин дүүд маань ээж урт куртик хийж өгсөн юм. Гэтэл нэг өдөр охин дүү минь их л ууртай гэртээ орж ирэв. Би ч юу болов гээд асуутал, “Ээж автобусны суудлын материалаар куртик оёод өгчихсөн байна. Автобусанд суусан чинь сандалтайгаа ижилхэн материалтай куртиктэй. Бүр шараа болчихлоо” гэж билээ. Энэ ээжална шүү. Кккkkkk

ТЭНГИС







Лаура үл мэдэгдэх Марина нэртэй охиныг фэйсбүүкийнхээ найзаас хассанаас хойш түүний хамгийн сайн найзууд нэг нэгээрээ хэрцгийгээр амиа алдаж эхэлнэ.

Гэртээ харьж явсан залуу цовоо цолгиун нэгэн бүсгүйтэй замдаа танилцаж хадлангийн бригад дээр хамтдаа ирснээр тэдний хувь заяа огт өөр өөр тийш эргэнэ. Гэхдээ амьдралд хэзээ ч тохиолдож болох гэнэтийн үйл явдлуудын өмнө залуус бэлэн байх болов уу?

